



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан
БШУ	Боловсрол шинжлэх ухаан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7000-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

ЕРӨӨ СУМЫН БУГАНТ ТОСГОНЫ
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.БАЯРЦЭНГЭЛ ТАНАА

2022.02.25 № СЭА-2022/116-НА-СТА-ТШЗ
тантай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	6,955,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	6,955,000.00
35400	Хангамжийн материал	0.00	6,955,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	6,955,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	917,006,106.11	974,367,133.47
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	917,006,106.11	974,367,133.47
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	910,336,356.10	967,716,133.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,208,528,470.00	1,290,528,470.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(365,786,676.35)	(392,793,071.84)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	23,659,213.00	34,849,213.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,075,053.42)	(8,549,272.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,079,664.00	38,694,664.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,699,311.60)	(8,703,032.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,483,672.81	21,483,672.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,853,622.34)	(7,794,509.60)
39300	Биет бус хөрөнгө	6,669,750.01	6,651,000.04
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,249.99)	(24,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,426,000.00	6,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	917,006,106.11	981,322,133.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	917,006,106.11	981,322,133.47
51	Засгийн газрын хувь оролцоо	917,006,106.11	981,322,133.47
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345,227,609.00	345,227,609.00
51200	Хуримтлагдсан үр дүн	385,054,335.92	449,370,363.28
51210	Өмнөх үеийн үр дүн	374,201,980.47	385,054,335.92
51220	Тайлант үеийн үр дүн	10,852,355.45	64,316,027.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,724,161.19	186,724,161.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	917,006,106.11	981,322,133.47

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	513,486,100.00	610,890,646.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,623,500.00	99,700,746.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,623,500.00	99,700,746.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,623,500.00	99,700,746.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,623,500.00	99,700,746.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,862,600.00	511,189,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	407,055,400.00	431,302,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	407,055,400.00	431,302,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	1,088,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	812,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	276,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,307,200.00	78,798,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,307,200.00	78,798,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	483,357,944.55	540,432,872.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,357,944.55	540,432,872.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,301,682.24	519,074,093.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,537,830.86	330,848,295.44
210101	Үндсэн цалин	190,975,034.41	226,670,100.00
210102	Нэмэгдэл	69,057,296.45	56,610,495.44
210104	Урамшуулал	21,732,300.00	24,316,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,773,200.00	23,250,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,067,587.83	44,186,800.00
210201	Тэтгэврийн даатгал	26,215,414.23	30,658,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,086,388.16	3,382,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,469,109.22	2,705,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,423.07	676,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,724,253.15	6,764,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,478,000.00	76,758,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,428,980.00	3,639,593.07
210302	Түлш, халаалт	54,433,620.00	60,519,106.93
210303	Цэвэр, бохир ус	1,615,400.00	12,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,418,400.00	3,920,700.00
210401	Бичиг хэрэг	233,000.00	618,000.00
210402	Тээвэр, шатахуун	642,400.00	514,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124,000.00	1,054,000.00
210404	Ном, хэвлэл	31,400.00	141,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,141,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,287,600.00	451,100.00
2105	Нормативт зардал	26,169,506.00	18,962,325.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	597,600.00	1,835,900.00

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	24,556,806.00	15,817,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,015,100.00	1,308,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,572,500.00	2,688,600.00
210604	Урсгал засвар	6,572,500.00	2,688,600.00
2107	Томилолт, зочны зардал	156,300.00	199,300.00
210702	Дотоод албан томилолт	156,300.00	199,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,162,600.00	1,721,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	588,600.00	749,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,738,957.55	39,787,472.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	907,500.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,032,000.00	2,343,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,799,457.55	37,443,972.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,056,262.31	21,358,779.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,056,262.31	21,358,779.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,056,262.31	21,358,779.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	30,128,155.45	70,457,773.36
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,275,800.00	6,141,746.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	5,115,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	19,275,800.00	1,026,746.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(19,275,800.00)	(6,141,746.00)
VI	НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,852,355.45	64,316,027.36

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	472,862,600.00	511,189,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,862,600.00	511,189,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	407,055,400.00	431,302,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	1,088,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	812,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	276,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,307,200.00	78,798,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,307,200.00	78,798,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	467,342,600.00	511,189,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,342,600.00	511,189,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,286,337.69	489,831,120.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,299,449.86	330,848,295.44
210101	Үндсэн цалин	190,736,653.41	226,670,100.00
210102	Нэмэгдэл	69,057,296.45	56,610,495.44
210104	Урамшуулал	21,732,300.00	24,316,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,773,200.00	23,250,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,067,587.83	44,186,800.00
210201	Тэтгэврийн даатгал	26,215,414.23	30,658,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,086,388.16	3,382,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,469,109.22	2,705,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,423.07	676,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,724,253.15	6,764,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,478,000.00	76,758,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,428,980.00	3,639,593.07
210302	Түлш, халаалт	54,433,620.00	60,519,106.93
210303	Цэвэр, бохир ус	1,615,400.00	12,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,411,500.00	3,600,700.00
210401	Бичиг хэрэг	153,000.00	298,000.00
210402	Тээвэр, шатахуун	647,500.00	514,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124,000.00	1,054,000.00
210404	Ном, хэвлэл	111,400.00	141,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,141,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,275,600.00	451,100.00
2105	Нормативт зардал	24,204,000.00	18,063,325.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	597,600.00	936,900.00
210502	Хоол, хүнс	22,579,300.00	15,817,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,027,100.00	1,308,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,672,500.00	11,388,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,100,000.00	8,400,000.00
210604	Урсгал засвар	6,572,500.00	2,988,600.00
2107	Томилолт, зочны зардал	156,300.00	199,300.00
210702	Дотоод албан томилолт	156,300.00	199,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,162,600.00	1,721,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	588,600.00	749,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,354,400.00	3,063,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	907,500.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,446,900.00	3,063,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,056,262.31	21,358,779.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,056,262.31	21,358,779.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,056,262.31	21,358,779.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	500,000.00	8,400,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,520,000.00	8,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,520,000.00	8,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,520,000.00	8,400,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,520,000.00)	(8,400,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0,00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	374,201,980.47	906,153,750.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	374,201,980.47	906,153,750.66
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,852,355.45	10,852,355.45
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	385,054,335.92	917,006,106.11
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	385,054,335.92	917,006,106.11
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	64,316,027.36	64,316,027.36
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	449,370,363.28	981,322,133.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	510,101,400.00	510,101,400.00	0.00	100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	510,101,400.00	510,101,400.00	0.00	100.00%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510,101,400.00	488,742,620.44	21,358,779.56	95.81%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,216,400.00	330,848,295.44	4,368,104.56	98.70%
210101	Үндсэн цалин	226,670,100.00	226,670,100.00	0.00	100.00%
210102	Нэмэгдэл	60,978,600.00	56,610,495.44	4,368,104.56	92.84%
210104	Урамшуулал	24,316,800.00	24,316,800.00	0.00	100.00%
210105	Гэрээт ажлын хөлс	23,250,900.00	23,250,900.00	0.00	100.00%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,186,800.00	44,186,800.00	0.00	100.00%
210201	Тэтгэврийн даатгал	30,658,200.00	30,658,200.00	0.00	100.00%
210202	Тэтгэмжийн даатгал	3,382,200.00	3,382,200.00	0.00	100.00%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,705,700.00	2,705,700.00	0.00	100.00%
210204	Ажилгүйдлийн даатгал	676,400.00	676,400.00	0.00	100.00%
210205	Эрүүл мэндийн даатгал	6,764,300.00	6,764,300.00	0.00	100.00%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,758,700.00	76,758,700.00	0.00	100.00%
210301	Гэрэл, цахилгаан	4,189,200.00	3,639,593.07	549,606.93	86.88%
210302	Түлш, халаалт	59,969,500.00	60,519,106.93	-549,606.93	100.92%
210303	Цэвэр, бохир ус	12,600,000.00	12,600,000.00	0.00	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,324,700.00	3,324,700.00	0.00	100.00%
210401	Бичиг хэрэг	298,000.00	298,000.00	0.00	100.00%
210402	Тээвэр, шатахуун	514,500.00	514,500.00	0.00	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,054,000.00	1,054,000.00	0.00	100.00%
210404	Ном, хэвлэл	141,800.00	141,800.00	0.00	100.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	865,300.00	865,300.00	0.00	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	451,100.00	451,100.00	0.00	100.00%
2105	Нормативт зардал	33,917,500.00	17,250,825.00	16,666,675.00	50.86%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,400.00	124,400.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	32,484,400.00	15,817,725.00	16,666,675.00	48.69%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,308,700.00	1,308,700.00	0.00	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,388,600.00	11,388,600.00	0.00	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,400,000.00	8,400,000.00	0.00	100.00%
210604	Урсгал засвар	2,988,600.00	2,988,600.00	0.00	100.00%
2107	Томилолт, зочны зардал	199,300.00	199,300.00	0.00	100.00%
210702	Дотоод албан томилолт	199,300.00	199,300.00	0.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,045,900.00	1,721,900.00	324,000.00	84.16%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	749,900.00	749,900.00	0.00	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	972,000.00	324,000.00	75.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,063,500.00	3,063,500.00	0.00	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,063,500.00	3,063,500.00	0.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	21,358,779.56	-21,358,779.56	
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	

2135	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	21,358,779.56	-21,358,779.56	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	21,358,779.56	-21,358,779.56	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	510,101,400.00	510,101,400.00	0.00	100.00%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	431,302,700.00	431,302,700.00	0.00	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	431,302,700.00	431,302,700.00	0.00	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	78,798,700.00	78,798,700.00	0.00	100.00%
320001	Орон нутгийн төсвөөс	78,798,700.00	78,798,700.00	0.00	100.00%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	310.00	310.00	0.00	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.00	34.00	0.00	100.00%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00%
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	0.00	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	241.00	241.00	0.00	100.00%
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	1.00	0.00	100.00%
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00	0.00	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.00	34.00	0.00	100.00%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30.00	30.00	0.00	100.00%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	0.00	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,088,500.00	(1,088,500.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,088,500.00	(1,088,500.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,088,500.00	(1,088,500.00)
2104	Хангамж, бараа материалын зардал		276,000.00	(276,000.00)
210401	Бичиг хэрэг		-	-
210404	Ном, хэвлэл		-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		276,000.00	(276,000.00)
2105	Нормативт зардал		812,500.00	(812,500.00)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		812,500.00	(812,500.00)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		812,500.00	(812,500.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		276,000.00	(276,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн */Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь *“Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, цэцэрлэг, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна”* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 483,357.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,833.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,383.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,316.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал		6,955.0	6,955.0
Үндсэн хөрөнгө	917,006.1	974,367.1	57,361.0
Нийт хөрөнгө	917,006.1	981,322.1	64,316.0
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	917,006.1	981,322.1	64,316.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	917,006.1	981,322.1	64,316.0

Бараа материал дансны үлдэгдэл 6,955.0 мянган төгрөгөөр өссөн нь БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 815.7 мянган төгрөгийн, Ерөө сумын ЗДТГ-с 700.0 мянган төгрөгийн оношлуур, Бугант тосгоны захирагчийн албанаас 280.0 мянган төгрөгийн ариутгалын материал, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1,270.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, өмнөх аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан 5,115.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр орлогоор хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 58,750.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 59,975.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ 94,805.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 82,000.0 мянган төгрөгийн их засварын ажил хийгдсэн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2,790.0 мянган төгрөгийн ус шүүгч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6,730.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 8,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 5,115.0 мянган төгрөгийн бараа материалыг данс хооронд шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 981,322.1 мянган төгрөг болж 64,316.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 97,404.5 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 57,074.9 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн нь цалин, НДШ-ын зардал, тогтмол зардал өссөн нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд

захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 511,199.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 510,101.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 431,302.7 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 78,798.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 431,302.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 78,798.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 510,101.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 488,742.6 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 21,358.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 488,742.6 мянган төгрөг буюу 95.8 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 4,368.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 16,666.7 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардал 324.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ариутгал халдваргүйжүүлэлт БСГ-аас 276.0 мянган төгрөг, Ерөө сумын ЗДТГ-с 812.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

2. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 3,111.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 5 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгт 510,101.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 488,742.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.3 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 612.6 мянган төгрөгийн 1 акт тогтоож, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шууд худалдан авах босго үнээс давсан 15,817.7 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтад харьцуулалтын арга хэрэглээгүй, тендерийн урилгыг нийтэд зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх *“Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”*, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн 2 дахь *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 10,0 сая төгрөг”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,029.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,115.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 96.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоон, 15,817.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг 5,115.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүйгээр эрхлэгч П.Баярцэнгэлд ХАБ-ын нэмэгдлийг 96.5 мянган төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 15,817.7 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 **Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг	3	21,029.2	1	5,115.0	1	96.5			1	15,817.7

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.